



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2013 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Байгууллагын тэмдэг түших, хэвлэмэл  
хуудас хариуцах ажилтан томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.37, тус газрын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын тэмдэг түших, албан бичиг, захирамжлалын хэвлэмэл хуудас хариуцах ажилтнаар Архив, бичиг хэргийн эрхлэгч /Ө.Ариунтунгалаг/, хурлын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас хариуцах ажилтнаар Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-г тус тус томилсугай.
2. Архив, бичиг хэргийн эрхлэгчийн эзгүйд тэмдэг түших, албан бичиг, захирамжлалын хэвлэмэл хуудас хариуцан ажиллахыг Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д даалгасугай.
3. Газрын тэмдэг, хэвлэмэл хуудсыг батлагдсан зааврын дагуу ашиглаж байхыг Архив, бичиг хэргийн эрхлэгч, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА